



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

□ **Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай** □

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны “Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын түлш дамжуулах цехийн шинэчлэлийн төсөл”-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 8,653,300.00 (найман сая зургаан зуун тавин гурван мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ, 2,407,983.34 (хоёр сая дөрвөн зуун долоон мянга есөн зуун наян гурван төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Эрчим хүчний яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, төслийн удирдагч Б.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНХИШИГ

0001391

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 01 дүгээр сарын 04 нийгдрийн  
04... дугаар тогтоолын хавсралт



**"Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын  
түлш дамжуулах цехийн шинэчлэлийн төсөл"-ийн балансаас  
Эрчим хүчний яамны балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Бичгийн ширээ	2016.02.25	ш	2	519,800.00	1,039,600.00	181,930.00	857,670.00
2	Сандал	2016.02.25	ш	2	199,900.00	399,800.00	69,980.00	329,820.00
3	Хувцасны шкаф	2016.02.25	ш	1	589,900.00	589,900.00	103,240.00	486,660.00
4	Буйдан	2016.02.25	ш	1	980,000.00	980,000.00	171,500.00	808,500.00
5	Принтер /canon 3010/	2016.04.25	ш	1	389,000.00	389,000.00	129,666.67	259,333.33
6	Өнгөт принтер /epson/	2016.04.25	ш	1	499,000.00	499,000.00	166,333.33	332,666.67
7	Монитор /dell 21.5/	2016.04.25	ш	2	379,000.00	758,000.00	252,666.67	505,333.33
8	Компьютер /dell optiplex 9020/	2016.04.25	ш	2	1,999,000.00	3,998,000.00	1,332,666.67	2,665,333.33
<b>НИЙТ ДҮН:</b>						<b>8,653,300.00</b> (найман сая зургаан зуун тавин гурван мянга гурван зуун)	<b>2,407,983.34</b> (хоёр сая дөрвөн зуун долоон мянга есөн зуун наян гурван төгрөг гучин дөрвөн мөнгө)	<b>6,245,316.66</b> (зургаан сая хоёр зуун дөчин таван мянга гурван зуун арван зургаан төгрөг жаран зургаан мөнгө)